МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРТ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ ТААТАЙ ҮЕ ТОХИОЖ БАЙНА



Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлт"-ийн бодлого, барилга бүтээн байгуулалтын салбарыг дэлхийн зах зээлд гаргах, хөгжлийн томоохон бүтээн байгуулалтад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилготой ***"ТОГТВОРТОЙ БАРИЛГЫН ЭРИН" ОЛОН УЛСЫН ФОРУМЫГ МОНГОЛ УЛСАД АНХ УДАА 2023.06.14-15-ны*** *өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна. Уг арга хэмжээг Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг (*IFAWPCA*), МБҮА ТББ, БХБЯ хамтран зохион байгуулж байна. Уг арга хэмжээний талаар МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхантай уулзаж ярилцлаа.*

-Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг буюу **IFAWPCA гэж ямар байгууллага вэ? Энэ байгууллагын талаар товчхон дурдаач та?**

IFAWPCA буюу Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг нь дэлхийн 2-р дайны дараа барилга, бүтээн байгуулалтын салбарыг сэргээх зорилгоор Австрали, Хятад (Тайван), Индонез, Япон, Солонгос, Пакистан, Филиппин, Сингапур зэрэг 8 орны барилгын төлөөлөгчид санаачлан **1956 онд Филиппин Улсын Манила хотод** үүсгэн байгуулагдсан. Өнөөдөр IFAWPCA нь Зүүн Өмнөд Ази болон Өмнөд Азийн нийт 18 орны Барилгын ассоциациудын хамтын ажиллагааг дэмжиж, бүс нутгийн Засгийн газар болон Барилгын гэрээт гүйцэтгэгчдийн хооронд ашигтай харилцааг хөгжүүлж, иргэний болон барилгын төслүүдийг хэрэгжүүлэхэд нь дэмжин ажиллаж байна.

-МБҮА ТББ нь Монгол Улсаа төлөөлж IFAWPCA-д элссэний үр дүн, ач холбогдол юу вэ?

МБҮА ТББ нь 2009 онд үүсгэн байгуулагдаж, өөрийн эгнээндээ барилга, бүтээн байгуулалтын салбарт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулдаг томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, үл хөдлөх хөрөнгийн реалтор, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, архитектур, зураг төслийн чиглэлийн 160 гаруй гишүүн компаниудын бүтээн байгуулагчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, гишүүддээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэдэг салбарын мэргэжлийн, манлайлагч, үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болсон төрийн бус байгууллага юм. МБҮА ТББ нь 2015 онд **IFAWPCA-д гишүүнээр элсэж**, **2018 онд Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож,** үүнээс хойш IFAWPCA-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон нягт хамтран ажиллаж байна. Өнгөрсөн 2022.11.14-19-ний хооронд Мальдив Улсын Мале хотноо зохион байгуулагдсан **"IFAWPCA-ийн 45 дахь удаагийн Чуулган"-**ны үеэр зохиогдсон Сонгуулийн үеэр Ерөнхийлөгч Н.Баярсайхан миний бие IFAWPCA-ийн 2022-2024 оны УЗГ-ээр сонгогдон ажлаа эхлүүлээд байна.

Монголын барилгын компаниудын чадвар сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөн нэмэгдэж байна. Нөгөө талаас манай улс харьцангүй жижиг зах зээлтэй, хүн ам цөөтэй орон. Иймээс урт хугацаандаа Монголын компаниудаа Олон улсын зах зээл дээр гаргаж, тэдний дүрмийн дагуу тоглож сургахын тулд олон улсын зах зээлтэй холбож өгөх, тэдний сүлжээнд орох шаардлага тулгарна. Энэ ажлыг одооноос судалж, суурийг нь тавихад салбарын Олон улсын байгууллагуудын гишүүнчлэлд нэгдэж тэдэнтэй холбоо хэлхээ тогтоох замаар туршлага судлах, суралцах ажлууд чухал байгаа. IFAWPCA-д дэлхийн хамгийн том барилгын гүйцэтгэгч компаниудыг эгнээндээ нэгтгэсэн БНСУ, Япон, Австрали болон сүүлийн үед хурдтай хөгжиж буй Сингапур, Малайз улсуудын барилгын Гэрээлэгч нарын холбоод байдаг.

-Баяр хүргэе. IFAWPCA-ийн УЗГ-ээр сонгогдон ажиллана гэдэг нэр хүндийн асуудал байх. Та юун дээр төвлөрч ажиллахаар төлөвлөж байна вэ?

Баярлалаа. Өнгөрсөн чуулганы үеэр **IFAWPCA нь МБҮА ТББ-ыг Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)**, үүний дараа **БХБЯ** нь албан ёсны дэмжлэгийг үзүүлсний дагуу бид ФИДИК-т “Гишүүн холбоо” (Member Association)-оор элсэх өргөдлөө хүргүүлээд байна. Ингэснээр **Монгол Улсыг төлөөлөх Үндэсний гишүүн холбоо болох**, улмаар “Дэд гишүүн” (Associate Member), “Харьяа гишүүн” (Affiliate Member)-ээр элсэх хүсэлтэй хувь хүн, компани, байгууллагыг дэмжих, мөн ФИДИК-ээс олгодог зөвшөөрлийг Монгол Улсдаа олгох зэрэг нөхцөл бүрдэх бөгөөд цаашид барилга, хот байгуулалтын салбарт **ФИДИК-**ийн **ГЭРЭЭГ** хэрэгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, сурган таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг бүхий л ажлыг зохион байгуулахаас гадна үүнтэй уялдсан бусад боломжуудыг нээж өгөхөд нь дэмжиж туслах сургагч, зөвлөгч нь байснаар салбарын үйл ажиллагаанд оролцогч, хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч нарын хоорондын харилцааг зохицуулах, эрх тэгш байдлыг хангах, хамгаалан ажиллах үүрэгтэй болно. Өөрөөр хэлбэл ингэснээр Монгол Улсын барилгын салбарт Олон улсын гэрээ, эрх зүйн орчныг бий болгож, шинэ үсрэлт, шинэ эргэлтийг авчрах таатай үе тохиож байна.

-Түрүүн та ярианы эхэнд IFAWPCA нь 3үүн өмнөд Азийн 18 орныг нэгтгэсэн Гишүүн байгууллагуудтай гэж хэллээ. Монгол Улс бусад Гишүүн орнуудтайгаа ямар харилцаа холбоотой байдаг вэ?

МБҮА ТББ нь IFAWPCA-ийн Гишүүн орнуудтай байнгийн харилцаа холбоотой ажилладаг бөгөөд барилгын салбарт BIM цахим системийг нэвтрүүлж норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, бойжуулах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд Гишүүн орнуудын туршлага, хамтын ажиллагаа, нөлөөлөл түлхэц болдог. Тухайлбал БНСУ, Сингапуртай “Харилцан ойлголцох санамж бичиг”-т гарын үсэг зурсны дагуу хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах хүрээнд хамтран ажиллаж байна. Үүнд:

- 2018 онд: **БНСУ-ын Барилгын ассоциаци**. Энэ ажлын хүрээнд БНСУ-ын Барилгын ассоциацийн барилгын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан бол Солонгос дахь өндөр барилгуудын хотхон, газар доорх дэд бүтэц, ХАБ-ын үйл ажиллагаатай танилцах, Монгол Улс дахь барилга бүтээн



байгуулалтын ажилтай танилцах, экспертүүдийг солилцох зэрэг асуудлаар саналаа солилцох улмаар туршлагыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

- 2022 онд: **Сингапур Улсын Барилгын Ассоциаци**. Энэ ажлын хүрээнд Сингапурын барилгын салбарт нэвтрээд буй барилгын төслийн удирдлага, мэдээллийн нэгдсэн систем **“BIM”**-ийн асуудлаар тус улсын экспертийг Монгол Улсад зохион байгуулагдсан “BIM 2023” Форумд оролцуулж, туршлага судлуулж, улмаар энэхүү системийг Монгол Улсад нэвтрүүлснээр БХБЯ-ны энэ чиглэлийн бодлогыг дэмжих, барилгын салбарыг бүрэн цахимжуулах, зураг төсөл зохиогчдыг олон улсын зах зээлд гаргах, төсөвт өртөг, байгаль орчин, эрчим хүчний үр ашиг зэргийг харгалзан илүү оновчтой, зөв төлөвлөлтийг хийх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болох юм.
- Түүнчлэн, IFAWPCA нь **барилгын салбарын хүний нөөц, ажиллах хүчний** асуудлаар гишүүн орнууд хоорондоо **туршлага солилцож**, эхний ээлжид хоорондоо **ажиллах хүчин солилцох**, **гаргах** асуудлаа ярилцсаны дараа **Засгийн газруудыг хооронд нь ярилцуулж**, танилцуулж зөв зохистой, **хууль ёсны хүрээнд** бэлтгэл ажлаа хангахаар тохироод байна. Энэ асуудлын хүрээнд, салбарын мэргэжилтнүүдийг МСҮТ-өөр дамжуулан барилгын салбарт нэвтэрч буй шинэ техник, технологийг эзэмшүүлэх, өндөр ур чадвартай, бэлтгэгдсэн ажилтнуудыг бий болгох, сургалтын арга барилыг энэ чиглэлд өөрчлөх, практик дээр суурилсан сургалтыг илүү түлхүү өгөх асуудал дээр хамтран ажиллаж байгаа нь салбарын хүний нөөцийг хөгжүүлэх асуудалд ач холбогдлоо өгч байна.

-IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганыг Монгол Улсад зохион байгуулах нь юугаараа ач холбогдолтой юм бэ?

IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганыг зохион байгуулах эрхийг олгох шалгаруулалтад **МОНГОЛ УЛС** шалгарч, **2023.06.14-18-ны** өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна. **“ТОГТВОРТОЙ БАРИЛГЫН ЭРИН” ОЛОН УЛСЫН ФОРУМ-**ыг Монгол Улсад анх удаа зохион байгуулах гэж байгаа ба энэ форумд Австрали, Балба, Бангладеш, Малайз, Мальдив, Сингапур, БНСУ, Тайван, Тайланд, Хонг Конг, Филиппин, Энэтхэг, Япон, ХБНГУ зэрэг 14 орны 100 гаруй барилга, дэд бүтцийн бүтээн байгуулагчид, мэргэшсэн инженерүүд, экспертүүд биетээр нэг дор хуран цуглан чуулж, бүс нутгийн гэрээлэгч байгууллагууд болон Засгийн газар болон гэрээлэгчдийн харилцаа холбоог тогтоож өргөжүүлэх, олон улсын барилга, дэд бүтцийн техник, технологийн шийдлийг солилцох, гишүүн орнуудын хууль тогтоомжийг барилга байгууламжийн төсөлд хэрэгжүүлэх гэж байгаагаараа онцлогтой юм. Мөн энэ чуулганы Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр “МОНГОЛД

ЗОЧЛОХ ЖИЛ”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого ЦАХИМ МОНГОЛ (мэдээлэл технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, роботын технологийн ололтыг барилгын салбарт нэвтрүүлэх), ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ (байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг хэмнэх, барилга, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх технологийг судлах)-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг эхлүүлэн, хөтөлбөр төлөвлөгөөгөө төлөвлөн ажиллаж байна.

-Энэ чуулган нь бүс нутгийн хувьд нэлээн өндөр хэмжээний арга хэмжээ болох юм байна. Монгол Улсын Засгийн газар, төрийн байгууллагуудын дэмжлэг хэр байна вэ?

Монгол Улсын Ерөнхий сайд, Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн Дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрынхаа дэвшүүлэн тавьсан зорилт, Дэлхийн 187 орны хамт санал нэгтэй баталсан Азийн бүс нутагт Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг нь энэхүү IFAWPCA-ийн 42 дахь удаагийн ДУНД ХУГАЦААНЫ ЧУУЛГАНЫГ Монгол Улсад зохион байгуулах **“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЭРИН” ОЛОН УЛСЫН ФОРУМ**-ын цар хүрээгээрээ нягт нийцэж байгаа. Тиймээс ч уг арга хэмжээг дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлсэн байгаа. Мөн холбогдох салбарын яамдууд бүх талаар дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллахаар болсон.

-Форумын арга хэмжээний үеэр хөндөгдөх сэдвүүд нэлээн сонирхол татаж байна. Энэ илтгэл, туршлагуудыг Монгол Улсад нэвтрүүлэхээр зорьж байгаа юу?

Уг форум нь Газар хөдлөлтийн эрсдэлийг хэрхэн шийдвэрлэх вэ?, Эрчим хүчийг хэрхэн үр ашигтай зарцуулах вэ гэсэн хоёр хэсгээс бүрдэж байгаа бөгөөд дотоодын үндсэн илтгэгч нараас гадна Тайваниас Тайваний үндэсний их сургуулийн Барилгын инженерийн тэнхим, Үндэсний Хэрэглээний Судалгааны Лабораторийн Газар хөдлөлтийн инженерийн судалгааны үндэсний төвийн доктор (Ph.D), профессор Ноён Чун Че Чоу-Тайвань Улсын газар хөдлөлтөд тэсвэртэй барилга байгууламжийн туршлагын талаар ярих бол ХБНГУ-аас Нэмэх энергитэй, ногоон барилгад нарны эрчим хүчийг ашиглах нь сэдвээр Архитектур+ компанийн Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч, BBW-ийн Эксперт Уве Фикеншер, Төвлөрсөн бус эрчим хүчний шилжилтийг хэрхэн хийх талаар ХБНГУ-ын BBW-ийн Эксперт Герхард Майндл нар туршлагаа хуваалцана. Дашрамд дурдахад МБҮА ТББ нь Монгол Улсад төвлөрсөн эрчим хүчний системээс үл хамаарсан сэргээгдэх эрчим хүч түүний дотор нарны эрчим хүчийг ашигладаг барилга барих, барилгын дулаалгад байгалийн гаралтай хонины ноосны дулаалгын болон бусад барилгын материалыг ашиглах, ХБНГУ-ын hi-tech engineering технологийг Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөц болон түүхий эдийн онцлогтой хослуулан барилга барих технологийг боловсруулах зэрэг судалгааны ажлыг эхлүүлэхээр болоод байгаа. Энэ туршлагаа бас уг форумын үеэр танилцуулах юм.

-Саяхан Турк Улсад газар хөдөлж тус Улсад болоод хүн ардад үлэмж хэмжээний гарз, хохирол учирлаа. Тиймээс энэ форумаар Монгол Улсад ийм гамшиг нүүрлэвэл хэрхэн ажиллах талаар хэлэлцэж шийдвэрлэх нь гэж ойлголоо?

Монгол Улс газар хөдлөлтийн маш өндөр эрсдэлтэй бүсэд байрлаж байгаа гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа байх. Энэ форумыг хийх бэлтгэл ажлын үеэр ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газрын Дэд бүтэц, газар хөдлөлтийн тасгийн дарга, хурандаа Ж.Дамдинсүрэн, ШУТИС-ын Барилга архитектурын сургуулийн ахлах багш, Доктор (PhD) Ц.Цоггэрэл нартай уулзаж ярилцахад Монгол Улсад 2023 он гарснаар 3,5 магниутаас дээш газар хөдлөлт 29 удаа болсон нь аюул хэзээ ч нөмөрч магадгүйг илтгэхээс гадна болсон тохиолдолд хэрхэн урьдчилан сэргийлэх, яаж амиа авч гарах тухай гээд маш сонирхолтой илтгэлүүд, туршлагуудаас хуваалцана. Мөн Зүүн өмнөд азийн улс орнуудын бодит кейс, газар хөдлөлтөд тэсвэртэй, эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын шинэ технологи, материалын талаар мэдээлэл, илтгэл тавигдаж бизнес уулзалтууд явагдаж, харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах нөхцөлөөр хангагдах юм.

Танд баярлалаа

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан:

Монгол Улсын барилгын салбарт олон улсын гэрээ, эрх зүйн орчныг бий болгох таатай үе тохиож байна

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлт"-ийн бодлого, барилга бүтээн байгуулалтын салбарыг дэлхийн зах зээлд гаргах, хөгжлийн томоохон бүтээн байгуулалтад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилготой "ТОГТВОРТОЙ БАРИЛГЫН ЭРИН" ОЛОН УЛСЫН ФОРУМЫГ МОНГОЛ УЛСАД АНХ УДАА 2023.06.14-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна. Уг арга хэмжээг Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын



нийгэмлэг (IFAWPCA), МБҮА ТББ, БХБЯ хамтран зохион байгуулж байна. Уг арга хэмжээний талаар МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхантай уулзаж ярилцлаа.

-Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг буюу IFAWPCA гэж ямар байгууллага вэ? Энэ байгууллагын талаар товчхон дурдаач та?

-IFAWPCA буюу Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг нь дэлхийн II дайны дараа барилга, бүтээн байгуулалтын салбарыг сэргээх зорилгоор Австрали, Хятад (Тайван), Индонез, Япон, Солонгос, Пакистан, Филиппин, Сингапур зэрэг найман орны барилгын төлөөлөгчид санаачлан 1956 онд Филиппин Улсын Манила хотод үүсгэн байгуулагдсан.

»Төгсгөл нь VI нүүрт»

ЭНЭ ТУХАЙ

МБУА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: Монгол Улсын барилгын салбарт олон улсын гэрээ, эрх зүйн орчныг бий болгох таатай үе тохиож байна

«Түрүүч Гэндэр»

Өнөөдөр IFAWPCA нь Зүүн Өмнөд Ази болон Өмнөд Азийн нийт 18 орны барилгын ассоциацуудын хамтын ажиллагаат дамжлик, бүс нутгийн Засгийн газар болон Барилгын гэрээт гүйцэтгэгчийн хооронд ашигтай харилцаат хөгжүүлж, иргэний болон барилгын тестүүлэт харагжүүлэхад нь дэмжин ажиллаж байна.

-МБУА ТББ нь Монгол Улсаа төлөөлж IFAWPCA-д элсээний үр дүн, ач холбогдол юу вэ?

-МБУА ТББ нь 2009 онд үүсэн байгуулагдсан, өөрийн эгнээндээ барилга, бүтээн байгуулалтын салбарт идэвхтай үйл ажиллагаагаа явуулдаг томоохон хэрнэг оруулагч, хагжүүлагч, үл хөдлөх хөрөнгийн рөвлтор, барилга үүсгэгч, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийүүлэгч, архитектур, зураг төслийн чиглэлийн 100 гаруй гишүүн компаниудын бүтээн байгуулагчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгасан, гишүүдээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна төрийн зөрим чиг үүргийг гүйцэтгэдэг салбарын мэргэлийн, мэлэйлагч, үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болсон төрийн бус байгуулалга юм. МБУА ТББ нь 2015 онд IFAWPCA-д пүшүүнээр элсэж, 2018 онд Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, үүнээс хойш IFAWPCA-ийн үйл ажиллагаанд идэвхтай оролцон нягт хамтран ажиллаж байна. Өнгөрсөн 2022.11.14-19-ний хооронд Мальдив Улсын Male хотноо зохион байгуулагдсан "IFAWPCA-ийн 45 дахь удаагийн Чуулган"-ны үеэр зохиогдсон Сонгуулийн үеэр Ерөнхийлөгч Н.Баярсайхан миний бие IFAWPCA-ийн 2022-2024 оны УЗГ-ээр сонгогдон ажлаа эхлүүлээд байна. Монгол Улс нь хүн ам цөөтэй, жижиг зах зээлтэй ходой ч Монголын барилын компаниудын чадвар сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөн нэмэгдэж энэ хэрээр ч Монголын компаниудаа Олон улсын зах зээл дээр гарсан, тэдний дүрмийн дагуу тогтодог боловсын түлэ Олон улсад нэр хүнд бүхий салбарын төрийн бус байгуулагуудаар дамжлик, туршлага судалж, халаас холбоо тогтоох зөмлэр ихээх нь хамгийн зөв гарц гэж үзэж байна. Энэ холбоонд дөрвөй дамар тар дундаа хамгийн бэлэн үед болох Дубайд барилын мега төсөөүүд хэрэгжүүлж байгаа БНСУ-ын Самсыныйн гүйцэтгэгч нар Япон, Сингапур, Малайзын Барилын Гарааталч нар байдаг бөгөөд бид тэдэнтэй ойр дотно байж суралцах, туршлага судлах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй болов уу.

-Бэнр хүргэж. IFAWPCA-ийн УЗГ-ээр сонгогдон ажиллана гэдэг нэр хүндийн асуудал байх. Та юун дээр төвлөрч ажиллахаар төлөвлөж байна вэ?

-Баярлалаа. Өнгөрсөн чуулганы үеэр IFAWPCA нь МБУА ТББ-ыг Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК) үүний дараа БХБЯ нь албан ёсны дэмжлэгийг үзүүлэнэй дагуу бид ФИДИК-т "Гишүүн холбоо" (Member Association)-оор элсэх өрөдлөө хүргүүлэхэд байна. Ингэснээр Монгол Улсыг төлөөлөх Үндэсний гишүүн холбоо болох, улмаар "Дэд гишүүн" (Associate Member), "Харьяа гишүүн" (Affiliate Member)-аар элсэх хүсэлтэй хувь хүн, компани, байгууллагыг дэмжих, мөн ФИДИК-аас олгодог эмэшмэрлийг Монгол Улсдаа олгох зорог нөхцөл бүрдэх бөгөөд цаашид барилга, хот байгуулалтын салбарт ФИДИК-ийн ГЭРЭЭГ хэрэгжүүлэх, судлагчлах, түгээн дэлгэрүүлэх, сурган танилуулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорог бүхий л ажлыг эзэлэн байгуулахаас гадна үүнтэй уялдан бүсэд бэлэмжүүдыг нээж өгөхөд нь дэмжлэг үзүүлэх сургагч, зөвлөгч нь байснаар салбарын үйл ажиллагаанд оролцоч, хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэч, зураг төсөл эзэмсэгч нарын хооронцын харилцаат эзэмдүүлэх, эрх тэнц байдлыг ханган, хамгаалан ажиллах үүрэгтэй болно. Өөрөөр хэлбэл ингэснээр Монгол Улсын барилгын салбарт Олон улсын гэрээ, эрх зүйн орчныг бий болгох, шинэ үүсэлт, шинэ эргалтийг зөөрөх таатай үе тохиож байна.

-Түрүүн та зөрманы эхэнд IFAWPCA нь Зүүн өмнөд Азийн 18 орныг нэгтгэсэн Гишүүн байгууллагуудтай гэж хэллээ. Монгол Улс бусад Гишүүн орнуудтайгаа ямар харилцаа холбоотой байдаг вэ?

-МБУА ТББ нь IFAWPCA-ийн Гишүүн орнуудтай байнгын харилцаа холбоотой ажилладаг бөгөөд барилын салбарт BIM цахим системийг нэвтрүүлэх норм, нормативын бичиг бичгийг боловсронгуй болгох дэшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, бойжуулах, нутагшуулах, үйлдвэрлэлд жэтрүүлэхэд Гишүүн орнуудын туршлага, хамтын ажиллагаа, мэлэлэл тулэлэ болдог. Түүнээгээр Монгол Улсын төлөөлөх Үндэсний гишүүн холбоо болсноор IFAWPCA-ийн Гишүүн орнуудтай хамтран ажиллах боломж нээгдэнэ. Үүнд:

- **2018 онд:** БНСУ-ын Барилгын ассоциаци. Энэ жилын хүрээнд БНСУ-ын Барилын ассоциацийн барилгын түслэй эзэмжмэрэл олгох үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан



бол Солонгос дахь өндөр барилгуудын хэтлэн, газар доорх дэд бүтэц, ХАБ-ын үйл ажиллагаатай танилцж, Монгол Улс дахь барилга бүтээн байгуулалтын зөмлэй танилцаж, экспертүүдийг сонилцох зорог зөвлөлөө саналаа солилцох улмаар туршлалыг нэвтрүүлэхээр ажилладаг байна.

- **2022 онд:** Сингапур Улсын Барилын Ассоциаци. Энэ жилын хүрээнд Сингапурын барилгын салбарт нэвтрэх бүй барилын тестлийн удирдлага, мэдээлэлын нэгдсэн систем "BIM"-ийн асуудлаар туз улсын ажлэрлийг Монгол Улсад зохион байгуулагдсан "BIM 2023" Форумд оролцуулж, туршлага судлүүлэх, улмаар энэхүү системийг Монгол Улсад нэвтрүүлэхээр БХБЯ-ны зэ чиглэлийн бодлого дэмжих, барилгын салбарыг бүрэн цэхэлмүүлэх, зураг төсөл эзэлчдыг олон улсын зах зээлд гарах, төсөөт өртөг, байгаль орчин, орчим хүний үр ашиг зэрлэг хэрэглээг илүү оновчтой, зөв төлөвлөлтлий хийх нөхцөлий бүрдүүлэх боломжтой болсон юм.

Түүнчлэн, IFAWPCA нь барилгын салбарын хүний нөөц, ажлэрлэх хүчний асуудлаар гишүүн орнуудтай хоорондоо туршлага солилцох, зэний зэлэнд зөөрөндөө ажлэрлэх хүчин солилцох, гарган асуудлаа ярилцаны дараа Засгийн газруудыг зөөрөнд нь ярилцуулж, танилцуулж зөв зөөлөөсөй хүүгэ бэнь хүрээнд бэлгэдэл ажлэ жанлаавар төөрөөд байна. Энэ асуудлын хүрээнд, салбарын мэргэжилтнүүдийг МСҮТ-ээр дамжуулан барилын салбарт нэвтрэх бүй цөөн техник, технологийг эзэмшүүлэх, өндөр ур чадвартай, боттгэдэл ажилтнуудыг бий болгох, сургалтын эрэг барилыг эна чиглэлд өөчлөх, практик дээр суурилсан сургалтыг илүү түлхүү өгөх асуудал дээр хамтрэж ажиллаж байгаа нь салбарын хүний нөөцийг эзэмшүүлэх асуудлыг эн хэлбэлүүр өгч байна.

-IFAWPCA-ийн 42 дахь Дүнд хуралцаанд чуулганыг Монгол Улсад зохион байгуулах нь юугаараа ач холбогдолтой юм бэ?

-IFAWPCA-ийн 42 дахь Дүнд хуралцаанд чуулганыг зохион байгуулах эрхийг олгох шалгаруулалтад МОНГОЛ УЛС шалгаруулагдсан. 2023.05.14-16-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах гэж байна. "ТОГТВОРТОЙ БАРИЛГЫН ЭРИН" ОЛОН УЛСЫН ФОРУМ-ыг Монгол Улсад анх удаа зохион байгуулах гэж байгаа бэ энэ форумд, Австрали, Балба, Бангладеш, Малайз, Мальдив, Сингапур, БНСУ, Тайвань, Тайланд, Хонг Конг, Филиппин, Энэтхэг, Япон, ХБНГУ зэрэг 14 орны 100 гаруй барилга, дэд бүтцийн бүтээн байгуулагчид, мэргэжлэн инженерүүд, экспертүүд өнөөгөөр нэг дор хүрэн цугларч чуулж, бүс нутгийн гарааталч байгуулагууд болон Засгийн газар болон гарааталчдийн харилцаа холбоог тогтоож өргөжүүлэх, хүүгэ тогтоомжийг барилга байгуулалжий-тэсэлд хэрэжүүлэх гэж байгаагаараа онцлогтой юм. Мөн энэ чуулганыг Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр "МОНГОЛД ЗОЧЛОХ ЖИЛ", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого ЦАХИМ МОНГОЛ нэгдэлээр технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, роботын технологийн оролцыг бэрлэн салбарт нэвтрүүлэх). ХҮЛЭЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ (байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг хэмнэх, барилга, ак үйлдвэр, хот хөгжлын салбарын хүлээмжийн хийн ялгаралыг бууруулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх технологийг судлах)-ыг хэрэжжүүлэх асуудлын хүрээнд зохион байгуулагаар болгож ажлыг эхлүүлэн, хөтөлбөр төлөвлөгөөгөө төлөвлөн ажиллаж байна.

-Энэ чуулган нь бүс нутгийн хүнд нэлээн өндөр хэмжээний арга хэмээх болох юм байна. Монгол Улсын Засгийн газар, төрийн байгууллагуудын дэмжлэг хэр байна вэ?

-Монгол Улсын Ерөнхий сайд, Гамалгийн эрдэлгийг бууруулах Үндэсний зөвлөлийн Дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрынхаа даалгуулан тавьсан зорилт, Дэлхийн 187 орны хамт санал нэгтэй батлагдсан Азийн бүс нутагт Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны барилт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг нь эхлүү IFAWPCA-ийн 42 дахь удаагийн Дүнд хуралцаанд чуулганыг Монгол Улсад зохион байгуулахаар болсон.

-Форумын арга хэмжээний үеэр хөндөгдөх сэдвүүд нэлээн сонирхол татах байна. Энэ мэтгэл, туршлагуудыг Монгол Улсад нэвтрүүлэхээр зорьж байгаа юу?

-Уг форум нь Газар хөдлөлтийн эрсдэлийг хэрэлэ шийдвэрлэх вэ?. Эрчим хүчийг хэрхэн үр ашигтай зарцуулах вэ гээн хоёр хэсэгт бүрдэж байгаа бөгөөд дотоодын үндсэн илтгэгч нараас гадна Тайванаас Тайванийн үндэсний их сургуулийн Барилын инженерийн тэнхим, Үндэсний Хэрэглээний Судалгааны Лабораторийн Газар хөдлөлтийн инженерийн судалгааны үндэсний төвийн доктор (Ph.D), профессор Нойн Чун Че Чоу-Тайвань Улсын газар зөдлөлтэд тэсвэртэй барилга байгууламжийн туршлагын талаар эрх бэл ХБНГУ-аас Нимак энергитэй, нягсон барилгад нарны эрчим хүчийг ашиглах нь судлэгч Архитектур+ компанийн Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч, BBW-ийн Эксперт Үзэс Фиконцер, Технологи бүс эрчим хүчний шилжилтийг хэрэгн хийх талаар ХБНГУ-ын BBW-ийн Эксперт Гершард Майндл нар туршлагаа хуваалцана. Дээрэмд дурдсад МБУА ТББ нь Монгол Улсад төлөөсөн эрчим хүчний системээс үл хамаарсан сэргээгдэх эрчим хүч түүний дотор нарны эрчим хүчийг ашиглаар барилга барих, барилгын дулаалгад бэлэлэлийн гарааталч хонины ноосны дулаалгын бөлон бүсэд барилын материалыг ашиглах, ХБНГУ-ын hi-tech engineering технологийг Монголын сэрэгэдэг эрчим хүчний нөөц болон түүний эдийн онцлогтой хослуулан барилга барих технологийг бөлөөсрүүлэх зэрэг судалгааны ажлыг эхлүүлэхэр болоод байгаа. Энэ туршлагаа бас уг форумын үеэр танилцуулах юм.

-Саяхан Түрк Улсад газар хөдлөлт түс Улсад болоод хүн ардад үлэмж хэмжээний гарз, хохирол учирлаа. Тиймээс энэ форумаар Монгол Улсад иймэрхүү ажиллах талаар хэлэлцэж шийдвэрлэх нь гэж ойлголоо?

-Монгол Улс газар хөдлөлтийн маш өндөр эрсдэлтэй бүсэд байрлаж байгаа гэдлийгээ та бүхэн сайн мэдэж байгаа байх. Энэ форумыг хийх болгосн ажлын үеэр ОБЕГ-ын Ажиллагаанд удирдлагын газрын Дэд бүтэц, газар хөдлөлтийн төсөлийн дарга, хурандаа Ж.Дэмбэнсүрэн, ШУТИС-ын Барилга архитектурын сургуулийн ахлах багш, Доктор (PhD) Ц.Цэнгэлмаа нартай уулзаж ярилцахад Монгол Улсад 2023 он гаромаар 3,5 магнитуудаас дээш газар хөдлөлт 29 удаа болсон нь ажүл хааяа ч нэмэрч магадгүйг илтгэхээс гадна болсон тохиолдолд хэрхэн урьдчилан сэргийлэх, яаж амь нас гарах түүнийг газ мэш сонирсотой илтгэлүүд, туршлагуудаас хуваалцана. Мөн Зүүн өмнөд азийн улс орнуудын бодит кейс, газар хөдлөлтэд тэсвэртэй, эрчим хүчний хэмжлттэй нягсон барилын цөнэ технологи, материалын талаар мэдээлэл, илтгэл тавиадаг бизнес уулзалтууд явагдах, хэрилцэх болбо танилцуулах, хамтран ажиллах нөхцөлүүр хангагдах юм.

-Танд баярлалаа